

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭГ ӨӨРЧЛӨХ ТАЛААР “РИО ТИНТО” КОМПАНИАС ЯВУУЛЖ БУЙ БОДЛОГО СТРАТЕГИ

АГУУЛГА:



Хөрөнгө оруулалтын гэрээ(ХӨРоГ)-ний үндсэн зарчим,

Рио Тинто-гоос барьж буй стратеги,

Үүсээд буй нөхцөл байдал, үр дагавар.



ОЮУТОЛГОЙН ХОЛБОГДОХ ГЭРЭЭНҮҮД

1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭ

(2009.10.06)

Монгол Улсын Засгийн газар

Айвенхоу Майнз Монголия Инк ХХК,
Айвенхоу Майнз Лимитед,
Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед

2. ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ГЭРЭЭ

(2009.10.06-нд байгуулсан, 2011.06.08-нд
нэмэлт өөрчлөлт оруулсан)

Эрдэнэс МГЛ ХХК

Айвенхоу Оюу Толгой (БиВиАй) Лтд,
Оюу Толгой Нидерланд Би.Ви.,
Айвенхоу Майнз Монголия Инк ХХК

3. ХУВЬЦАА ШИЛЖҮҮЛЭХИЙГ ХЯЗГААРЛАХ ГЭРЭЭ

(2011.06.08)

Монгол Улсын Засгийн газар

Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед



ГЭРЭЭНД ЗААСАН САНХҮҮЖИЛТИЙН АРГА ХЭЛБЭРҮҮД


№	САНХҮҮЖИЛТИЙН АРГА ХЭЛБЭРҮҮД	САНХҮҮЖИЛТИЙГ ХИЙХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭД	САНХҮҮЖИЛТИЙГ БУЦААН ТӨЛӨГЧ
1	ЭНГИЙН ХУВЬЦААНЫ САНХҮҮЖИЛТ (ХНГ 11)	Рио Тинто өөрийн өмнөөс болон Засгийн газрын өмнөөс хийнэ.	Засгийн газар зөвхөн ногдол ашгаар хариуцна.
2	ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧИЙН ӨРИЙН САНХҮҮЖИЛТ(ХНГ 13)	Рио Тинто компани хийнэ.	“Оюу толгой” ХХК төлнө.
3	ГУРАВДАГЧ ЭТГЭЭДИЙН САНХҮҮЖИЛТ (ХНГ 14)	Гуравдагч этгээд хийнэ.	Оюу толгой” ХХК төлнө.

ГЭРЭЭ БОЛОН ТЭЗҮ-Д ТУСГАГДСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ


	Хамрах хугацаа	Хөрөнгө оруулалтын гэрээнд	Баталгаажуулсан дүн (Хувь нийлүүлэгчид, ТЭЗҮ-ийн дагуу сая \$)
Хувь нийлүүлэгчдийн одоогийн зээл (ХӨРoГ 16.19)	2010.03.31 хүртэлх	~1 тэрбум	677
Анхны хөрөнгө оруулалт(ХӨРoГ 9.5)	2010.03.31 - 2013	~4 тэрбум	4,425
ТЭЗҮ болон гэрээний дагуу төсөлд хийгдэх хөрөнгө оруулалт		~5 тэрбум	5,102

Оюу Толгой Компани: Засгийн Газар, Хөрөнгө Оруулагчийн хүртэх өгөөж

2010 онд батлагдсан ТЭЗҮ: Оюу Толгой компанийн ХО-ын болон ХНГэрээний санхүүгийн хувиарлалт
Сая ам.доллараар; Нэрлэсэн үнээр



2009 ОНД БАЙГУУЛСАН ХӨРОГ-НИЙ ҮНДСЭН ЗАРЧИМ



РИО ТИНТО-ГООС БАРЬЖ БУЙ СТРАТЕГИ: ХӨРОГ ӨӨРЧЛӨХ

1. **САНАМЖ БИЧГИЙН ТӨСӨЛ (2014.10.01)**
2. **ТАТВАРЫН АРГАЧЛАЛ БАЙГУУЛАХ АЛБАН ТООТ (2014.10.01)**
3. **ТУЗ-ИЙН ТӨЛӨВЛӨГДСӨН ХУРАЛ (2014.11.10)**

ХӨРОГ-Г ӨӨРЧЛӨХӨӨР РИО ТИНТО-ГООС ИРҮҮЛСЭН САНАМЖ БИЧГИЙН ТӨСӨЛ	“Рио Тинто”-гийн зүгээс Монгол Улсын Засгийн газартай байгуулахаар 2014 оны 10 дугаар сарын 1-нд ирүүлсэн. “Санамж бичиг”-ийн төсөл нь 4 бүлэг, 53 асуудлаас бүрдэж байна.
--	---

САНАМЖ БИЧГИЙН ТӨСӨЛ

Санамж бичгийн төсөл 4 бүлэг, 53 асуудал	Зорилго	Нийт	Заалт/Тайлбар
1. Ерөнхий зүйлс – 3 заалт, 2. Барилга, бүтээн байгуулалт – 21 заалт; I үе шат, ТЭЗҮ, зардлын өсөлт (6), II үе шат, ТЭЗҮ, эхлүүлэх нөхцөл (12), Менежментийн төлбөр (2), Би Эйч Би 2% роялти-(1) 3. Санхүүжилт – 16 заалт; 1. Төслийн санхүүжилт (14), 2. Менежментийн үйлчилгээний гэрээ (1), 3. Барьцаа, баталгаа (1), 4. Бусад асуудлууд – 5 заалт.	Монгол Улсын хууль тогтоомж, ХӨРОГ-ний үндсэн зарчим зөрчих	48	• 2012 оноос хойшхи асуудлууд шийдэгдсэн, • ТЭЗҮ-ээр Хувьцаа эзэмшигчид ногдох үр өгөөжид баталгаа гаргахгүй, • Төслийн үе шатыг дахин тодорхойлох, • 1-р үе шатны зардлын өсөлтийн дүнг баталгаажуулах, • 2-р үе шатыг зөвхөн асуудал шийдэгдэх тохиолдолд эхлүүлэх, • Ус, эрчим хүчний тарифыг тохиролцох механизмыг баталгаажуулах, • Роялтигийн тооцооллыг өөрчлөх, • Би Эйч Би-гийн роялти 2% гэх асуудлыг баталгаажуулах, • Санхүүжилтийн үүрэг хариуцлагаа Рио Тинто нь бусдад шилжүүлэх, эрсдэлээ бууруулах нөхцөлийг баталгаажуулах, • Гэрээгээр тохирсон Менежментийн багаас гадна Менежер гэсэн ойлголтыг шинээр бий болгох, нэмэлт төлбөр өгөх.
	Яриа хэлэлцээний явцад Монголын талд буулт хийсэн дүр үзүүлэх	5	• Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийлгэх, • Ханган нийлүүлэлтэд тавигдах хяналтыг ТУЗ-ийн дэд хороонд даалгах, • Би Эйч Би-гийн роялти 2% гэх асуудлаас татгалзах, • Нийт санхүүжүүлсэн дүнд Либор-6.5%-ийн хүү тооцох,

ХӨРОГ-Г ӨӨРЧЛӨХӨӨР РИО ТИНТО-ГООС ИРҮҮЛСЭН САНАМЖ БИЧГИЙН ТӨСӨЛ

“Рио Тинто”-гийн зүгээс Монгол Улсын Засгийн газартай байгуулахаар **2014 оны 10** дугаар сарын 1-нд ирүүлсэн “Санамж бичиг”-ийн төсөл нь **4** бүлэг, **53** асуудлаас бүрдэж байна.

1. ХӨРoГ, Хувь нийлүүлэгчдийн гэрээ(ХНГ) болон ТЭЗҮ-ийн үндсэн зарчим, хүртэх үр өгөөжийг өөрчлөх,	2. Хууль болон ХөОГ, ХНГ-ийн хүрээнд Монголын талаас хөндөж тавьсан асуудлуудыг шийдвэрлэгдсэн хэмээн хүлээн зөвшөөрүүлж, цаашид Монголын талыг эрхзүйн аливаа маргаан дахин үүсгэх боломжгүй болгох,	3. Хуулийн хүрээнд төлөх татвар, төлбөрийн хэмжээг бууруулах (роялти, ус, эрчим хүчний тариф),	4. Монгол Улсын хууль тогтоомжоор тогтоосон хэм хэмжээнээс зөрүүтэй зохицуулалтыг баталгаажуулах.	5. ХӨРoГ болон ХНГ байгуулсан бүх талууд оролцож гарын үсэг зурснаар энэхүү Санамж бичгээр гэрээнээс давж үйлчлэх эрхзүйн баримт бичгийг Монголын талаар баталгаажуулах,
--	---	--	---	--

САНАМЖ БИЧГИЙН ТӨСЛИЙН ХӨРОГ, ХНГ-ТЭЙ ҮЛ НИЙЦЭХ ЗАРЧМЫН 10 АСУУДАЛ:

ТЭЗҮ ↓ X ХөрОГ	1: Хууль болон ХӨРoГ, ХНГ зөрчөөгүй гэж баталгаажуулах
	2: ТЭЗҮ-г ач холбогдолгүй болгох - Үе шатуудад хуваах
	3: Талуудын үр өгөөжийг баталгаажуулах болгох
	4: Далд уурхайг эхлүүлэх болзолт нөхцөл – ТЭЗҮ хүлээн авах, эрчим хүч, усны тариф
	5: Татварын аргачлал–Роялти, Суутган татвар, Хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлт
	6: “Би Эйч Би 2% роялти” гэх нэмэлт төлбөр
	7: Рио Тинто төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг ашиглах эрх авах - 4.2 тэрбум ам.доллар
	8: Төслийн санхүүжилтээс РТ нэмэлт, ашиг хураамж авах
	9: Төслийн санхүүжилтийн барьцаа баталгаа
	10: Менежментийн үйлчилгээний нэмэлт гэрээ байгуулан нэмэлт төлбөр авах

Жич: Санамж бичгийн заалтын дарааллаар жагсаав.

ХӨРОГ БОЛОН ХНГ-НД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХДАА..

Засгийн газар (4 сайд)	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭ (ХөрОГ 15.30) Талууд бичгээр харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.	Рио Тинто, Туркойз Хилл, Оюу Толгой
Upon mutual consent recorded in writing, the Parties may amend or modify this Agreement.		
ЭМГЛ (ЭОТ)	ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ГЭРЭЭ (ХНГ 24.6) Талууд зөвхөн өөр гэрээ байгуулах замаар энэхүү Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.	Айвенхоу Оюу Толгой БиВиАй Лтд Оюу Толгой Нидерланд Би.Ви.
This Agreement may be amended only by another agreement executed by all the Parties.		

АСУУДАЛ 1: ХУУЛЬ БОЛОН ХӨРОГ, ХНГ-ИЙН ГЭРЭЭ ЗӨРЧӨӨГҮЙ ГЭЖ БАТАЛГААЖУУЛАХ

Хөрөнгө оруулалтын гэрээ

1. ХӨРОГ-ний зорилго хэсэгт “...Хөрөнгө оруулагчийн татварын болон үйл ажиллагааны орчинг тодорхой хугацаанд тогтвортой байлгах...”

2. ХӨРОГ 1.3 – “Энэхүү Гэрээний 2.24.2-т зааснаас бусад тохиолдолд Хөрөнгө оруулагчийн төлбөл зохих Татварууд /энэхүү Гэрээний 2.1 болон 2.24-т тодорхойлсноор/-ыг тогтворжуулна.”

3. ХӨРОГ 1.10 – “Энэхүү Гэрээгээр зохицуулагдаагүй аливаа харилцааг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, Монгол Улсын олон улсын гэрээний дагуу шийдвэрлэнэ.”

Санамж бичгийн төсөл – Ерөнхий зүйл

1.1. Энэхүү Санамж Бичгийн 2.5 дахь Угтвар нөхцөлүүдийг хангасны үндсэн дээр, 2012 оны 10 дугаар сараас хойш хөндөгдөж ирсэн асуудлууд бүрэн шийдэгдсэн бөгөөд ХөОГ болон НӨОДТХНГ-ээр тохирсон дагаж мөрдөх ёстой нөхцөлүүдийг дахин нотлож байна.

1.2. ХөОГ-нд тусгагдсан хуулийн болон татварын тогтворжуулалтын тухай заалтуудын хүрээнд ХөОГ болон Монгол Улсын хуулийн дагуу Монгол Улсын холбогдох бүх хууль тогтоомжийг ОТ ХХК нь даган биелүүлэх үүрэг хүлээнэ.

1.3. ОТ ХХК, Рио Тинто болон ТРК нь Хөрөнгө оруулалтын гэрээ, Хувь нийлүүлэгчдийн гэрээ болон Монгол Улсын хууль тогтоомжийг санаатайгаар болон ноцтойгоор зөрчсөн хэмээн буруутгах зөрчил байхгүйг Засгийн газрын этгээдүүд нотлон, хүлээн зөвшөөрч байна.”

ДҮГНЭЛТ:

1. Хууль болон ХӨРОГ, ХНГ-ний хүрээнд Рио Тинто, ТРК, ОТ ХХК нь ямар нэг зөрчил үүсгээгүй гэдгийг Монголын талаар хүлээн зөвшөөрүүлж, цаашид Монголын талыг эрхзүйн маргаан үүсгэх боломжгүй болгох,
2. ХӨРОГ-ээр зөвхөн татвар болон үйл ажиллагааны орчинг тогтворжуулсан байтал хууль тогтворжуулсан гэсэн агуулгыг хүлээн зөвшөөрүүлж, нэмж баталгаажуулах ,

АСУУДАЛ 2: ТЭЗҮ-Г АЧ ХОЛБОГДОЛГҮЙ БОЛГОХ

Хөрөнгө оруулалтын гэрээ

16.10 “барилгын ажил гүйцэтгэх хугацаа” гэж Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дараах тохиолдлын аль түрүүлж болох хүртэл хугацааг:

16.10.1 хүчин төгөлдөр болох өдрөөс хойш 7 /долоо/ жилийн дараа;

16.10.2 Баяжуулах үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхлэх.

16.7 “үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлсэн өдөр” гэж барилгын ажлын тухайн үе шатанд баяжуулах үйлдвэрийн төлөвлөгөөт хүчин чадлын 70 /дал/ хувийг ашиглан 30 /гуч/ өдрийн турш тасралтгүй бүтээгдэхүүн гаргаж, Оюу толгой төслөөс хэрэглэгч нарт тогтмол тээвэрлэн хүргэж эхэлсэн сарын дараагийн сарын эхний өдрийг хэлнэ. Энэ нь баяжуулах үйлдвэрийн хүчин чадлыг бүрэн ашиглах хугацаанаас өмнө тохиож болох бөгөөд энэ тухай Хөрөнгө оруулагч Засгийн газарт мэдэгдсэн байна;

Санамж бичгийн төсөл – Барилга, бүтээн байгуулалт

2.1. Хөрөнгө оруулалтын гэрээний 9.6-ийн дагуу ОТ төслийг үе шаттайгаар хэрэгжүүлж болно. Энэхүү санамж бичигт тусгаснаар

А. I үе шат гэж ОТ төслийн ил уурхай, баяжуулах үйлдвэр, түүнд шаардагдах дэд бүтэц, анхан шатны босоо ам болон далд уурхайн хөндлөн малталтын бүтээн байгуулалт, эхлүүлэх шатны ажлууд

Б. II үе шат гэж далд уурхайн Хойд Хюга давхарга I-ийн барилгын ажил болон баяжуулах үйлдвэрийн өөрчлөлт, далд уурхайн хүдрийг гаргах дэд бүтэц

Хувь нийлүүлэгчдийн гэрээ

7.4 (в) Менежментийн үйлчилгээний төлбөрийн хэмжээ нь:

(i) **Гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлсэн өдөр** хүртэлх хугацаанд тухайн хугацаанд гарсан Үндсэн хөрөнгийн зардал болон Үйл ажиллагааны зардлын нийт дүнгийн 3 (гурван) хувь;


(ii) **Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс хойшхи хугацаанд** гарсан Үндсэн хөрөнгийн зардал болон Үйл ажиллагааны зардлын нийт дүнгийн 6 (зургаан) хувь байна.

ДҮГНЭЛТ:

1. 2010 оны ТЭЗҮ, ХӨРОГ-гээр төслийг цаг хугацааны үндсэн 2 үед хуваахаар тохиролцсоныг өөрчлөх, цаашид үе шатууд гэсэн ойлголт бий болгох,
2. ХӨРОГ байгуулах эдийн засгийн суурь үндэслэл болсон ТЭЗҮ-ийн томъёоллыг өөрчлөх, ач холбогдолгүй болгох,

ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ, ӨӨРЧЛӨЛТҮҮД

Техник эдийн засгийн үндэслэл нь а) Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах б) Төслийн санхүүжилтийг босгоход баримтлах суурь баримт бичиг юм. ТЭЗҮ-ийн тооцоололд суурилан хөрөнгө оруулагчид хувьцаа худалдан авч, банкууд зээлээ олгосон билээ.



- 1 – ОТ 2014 ТЭЗҮ: Table 1-26
- 2 - ОТ 2014 ТЭЗҮ: Table 1-13; Payback period Table 1-9
- 3 - ОТ 2014 ТЭЗҮ: Хуудас 1-33
- 4 - ОТ 2010 ТЭЗҮ: Хуудас 90
- 5 - ОТ 2014 ТЭЗҮ: Хуудас 1-45

2010 ҮНДСЭН ЗАРЧИМ

РИО ТИНТО ТАКТИК



АСУУДАЛ 3: ТАЛУУДЫН ҮР ӨГӨӨЖИЙГ БАТАЛГААГҮЙ БОЛГОХ

Хөрөнгө оруулалтын гэрээ

1. ХӨРОГ 3.10.3.1 Хөрөнгө оруулагч нь энэхүү Гэрээний 1.11-д заасан Техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу Оюу толгой төслийг бүрэн барьж ашиглалтад оруулахад шаардагдах санхүүгийн хангалттай эх үүсвэрийг баталгаа, барьцаа, бусад хэлбэрийн дэмжлэгийг Хөрөнгө оруулагч хүлээн авахуйц нөхцөлөөр баталгаажуулж, /эсхүл бэлэн болгож/ энэ тухайгаа Засгийн газарт бичгээр мэдэгдсэн өдөр, эсхүл

2. ХӨРОГ 9.5 Хөрөнгө оруулагч нь Айвенхоу Майнз Лимитед болон Рио Тинтогийн санхүүгийн чадамжаар бүрдсэн Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлээр Оюу толгой төслийн хайгуул болон бүтээн байгуулалтад ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн болно. Хөрөнгө оруулагч нь энэхүү Гэрээний 3.6-д заасан Техник, эдийн засгийн үндэслэлд тусгасан ойролцоогоор 4 тэрбум долларын нэмэлт хөрөнгө оруулалтыг Оюу толгой төсөлд хийхээр төлөвлөж байна. Тооцоолсон эхний хөрөнгө оруулалтыг 5 /тав/ жилийн хугацаанд хийх бөгөөд хөрөнгө оруулалтын зардлын энэ хуваарийг Техник, эдийн засгийн үндэслэлд тусгана.

Санамж бичгийн төсөл – Барилга, бүтээн байгуулалт

2.3. Хэдийгээр ТЭЗҮ-ийг заавал дагаж мөрдөх шаардлагагүй, аливаа хувьцаа эзэмшигчид ногдох үр өгөөжид баталгаа гаргах боломжгүй боловч, II үе шатны ТЭЗҮ-ийн тооцоололд суурилан талууд энд тэмдэглэснээр, Оюутолгой төслийн ашиг, эдийн засгийн үр өгөөж нь ерөнхийдөө 2010 оны ТЭЗҮ-д тусгагдсантай нийцэж байгаа бөгөөд Засгийн газар нь төслийн нийт хугацаанд нийт үр өгөөжийн 53% хүртэнэ (үүний дийлэнх нь татвар болон роялти-гаас бүрдэнэ).

ДҮГНЭЛТ:

1. ХӨРОГ байгуулах эдийн засгийн суурь үндэслэл болсон ТЭЗҮ-ийн томъёоллыг өөрчлөх, ач холбогдолгүй болгох,
2. ТЭЗҮ нь ерөнхий төсөөлөл, таамаг гэдгийг хүлээн зөвшөөрүүлж, батлагдсан ТЭЗҮ-д тусгагдсан Монголын талын хүртэх үр ашгийн хэмжээг тодорхойгүй болгох,

АСУУДАЛ 4: ДАЛД УУРХАЙГ ЭХЛҮҮЛЭХ БОЛЗОЛТ НӨХЦӨЛ

Хөрөнгө оруулалтын гэрээ

ХӨРОГ-ний зорилго хэсэгт “Гэрээнд гарын үсэг зурсан Талууд түүгээр тодорхойлогдсон эрх, үүргийг заавал биелүүлэх үүрэг хүлээж, дараах нөхцөлтэйгээр харилцан тохиролцов.”

ХӨРОГ 10.7 – “Хөрөнгө оруулагч нь давагдашгүй хүчин зүйлийнхээс бусад шалтгаанаар энэхүү Гэрээгээр хүлээсэн үндсэн болон ач холбогдол бүхий үүргээ биелүүлэлгүй 6 /зургаа/ сарын хугацаа өнгөрсөн, эсхүл Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журмыг санаатайгаар болон ноцтойгоор зөрчсөн бол...”

ХӨРОГ 7.4 – “Засгийн газар Хөрөнгө оруулагчийг цахилгаан эрчим хүчээр хангах тохиолдолд Хөрөнгө оруулагчийн төлөх бүх үнэ, тариф, төлбөр, хураамжийг үл ялгаварлах зарчимд тулгуурлан тогтооно.”

ХӨРОГ 6.14 – “Хөрөнгө оруулагч уурхайг ашиглалтад оруулах, олборлолт хийх зорилгоор ашигласан, зайлуулсан, гадаргын болон гүний усны төлбөрийг тухайн үед мөрдөж байгаа Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасан хувь хэмжээгээр тооцож, төсөвт төлөх бөгөөд уг төлбөрийг Хөрөнгө оруулагчийн албан татвар ногдох орлогоос хасч тооцох ба Хөрөнгө оруулагчийн ус ашиглах нөхцөлүүд нь дотоод, гадаадын бусад ус ашиглагчтай адил байх бөгөөд уг ус нь үйлдвэрийн буюу ахуйн хэрэгцээнд тохиромжтой эсэхийг харгалзан үзнэ.”

Санамж бичгийн төсөл – Барилга, бүтээн байгуулалт

2-р үе шат зөвхөн дараах нөхцөл хангагдсан тохиолдолд эхэлнэ. Үүнд:

а. 2-р үе шатны ТЭЗҮ-г Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөл болон Рио Тинто, Туркойс Хилл, ОТ ХХК-ийн ТУЗ зөвшөөрч баталсан байх (2014 оны 2-р хагаст багтаах таамагтай байгаа);

б. Шийдэгдээгүй үлдсэн хувьцаа эзэмшигчийн аливаа асуудал, маргаан, санал зөрөлдөөн байхгүй байх;

в. Төслийн санхүүжилтийг багтаасан Санхүүжилтийн цогц төлөвлөгөөг (дорх 3-р заалтад тодорхойлсон) зөвшөөрсөн; мөн

г. Холбогдох бүх зөвшөөрлийг авсан байх, мөн ОТ ба ОТ ХХК-д хамаарах хэрэглээний үнэ тарифууд, тухайлбал цахилгаан эрчим хүч, усны тарифуудыг тогтоох бүтцийг тохиролцсон байх,

д. ХӨОГ-ний ОТ төсөлд хамааралтай татварын хуулиудтай нийцүүлэх шаардлага, түүний үйлчлэл болон хэрхэн тайлбарлагдахыг тодруулах, баталгаажуулах цогц ерөнхий зарчим бүхий татварын журамд ОТ ХХК болон ТЕГ тохиролцлоо (“II үе шатны утвар нөхцөлүүд”).

ДҮГНЭЛТ:

1. ХӨРОГ-ээр хүлээсэн үндсэн үүргээ биелүүлэхдээ маргаантай байгаа бүх асуудалд Монголын талаар бүрэн буулт хийлгэх болзолт нөхцөл тулгаж байгаа нь ХӨОГ ноцтой зөрчиж байгаа үйлдэл,
2. ХӨРОГ -ээр тогтворжуулаагүй эрчим хүч, усны төлбөрийг хуульд заасан хувь хэмжээгээр тооцох бус тогтворжуулах механизмыг баталгаажуулах,

АСУУДАЛ 5: ТАТВАРЫН АРГАЧЛАЛ

Хөрөнгө оруулалтын гэрээ

5

ХӨРӨГ 3.13. “Хөрөнгө оруулагч нь энэхүү Гэрээ байгуулсан өдөр хүчин төгөлдөр мөрдөж байсан Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3.2-т заасны дагуу Гэрээт талбайгаас олборлож худалдсан, худалдахаар ачуулсан, эсхүл өөрөө ашигласан бүх Бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 5 /тав/ хувиар тооцож ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төлөх бөгөөд төлбөрийг тогтворжуулна.”

Санамж бичгийн төсөл –

Барилга бүтээн байгуулалт

Энэхүү Санамж бичгийн 2.7(е)-д заасан Татварын аргачлал дараахийг багтах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй; үүнд
i. 2014 оны 6-р сарын 20-ны өдрийн Татварын байцаагчийн акт болон Татварын Маргаан таслах зөвлөлийн 2014 оны 77 Тогтоолтой холбоотойгоор үүссэн маргааныг шийдвэрлэх,

2.8 ii. Хөрөнгө оруулалтын гэрээний дагуух ОТ ХХК-ийн **Хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлтийн дүн**,

iii. ОТ ХХК-ийн санхүүгийн тайландаа бүртгэн худалдаж авсан бүх бараа, ажил үйлчилгээг Монгол Улсад оруулсан хууль ёсны хөрөнгө оруулалт гэж үзэх бөгөөд нягтлан бодох бүртгэл, татварын зорилгоор тооцож байх шаардлага,

iv. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох аргачлал,
v. Гэрээ болон тодруулга шаардлагатай бусад асуудал.

ДУГНЭЛТ:

1. ХӨРӨГ-ээр хүлээсэн үндсэн үүргээ биелүүлэхдээ маргаантай байгаа бүх асуудалд Монголын талаар бүрэн буулт хийлгэх болзолт нөхцөл тулгаж байгаа нь ХӨРӨГ ноцтой зөрчиж байгаа үйлдэл,
2. ХӨРӨГ-ээр тогтворжуулаагүй эрчим хүч, усны төлбөрийг хуульд заасан хувь хэмжээгээр тооцох бус тогтворжуулах механизмыг баталгаажуулах,

АСУУДАЛ 6: “БИ ЭЙЧ БИ 2% РОЯЛТИ” ГЭХ ТӨЛБӨР

Хөрөнгө оруулалтын гэрээ

7

ХӨРӨГ 1.10 – “Энэхүү Гэрээгээр зохицуулагдаагүй аливаа харилцааг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, Монгол Улсын олон улсын гэрээний дагуу шийдвэрлэнэ.”

Санамж бичгийн төсөл –

Барилга бүтээн байгуулалт

2.10

Туркойс Хилл нь ОТ ХХК-иас 2%-ийн Хайлуулагчийн цэвэр буцаалт (цаашид ХЦБ гэх) авах эрхтэй. Туркойс Хилл болон Рио Тинто эсхүл аль нэг өөр этгээд ХЦБ-ын төлбөрийг ОТ ХХК-иас авах эрхгүй болохоо зөвшөөрч байна.”

ДУГНЭЛТ:

1. ХӨРӨГ-ээр огт тохиролцоогүй “Би Эйч Би 2%” гэх төлбөрийг шийдвэрлэгдээгүй асуудал болгож яриа хэлэлцээнд хийсэн буулт болгон ашиглаж байна.
2. Энэ асуудлыг санамж бичигт тусгаж манай талаар асуудал гэдгийг хүлээн зөвшөөрүүлснээр цаашид эрхзүйн маргаан үүсгэх боломжийг Туркойс Хиллд бүрдүүлж байна.

АСУУДАЛ 7: ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР

Хувь нийлүүлэгчдийн гэрээ

8

ХНГ 14.в - “Компанид зориулан аливаа Хувь нийлүүлэгч болон/эсхүл АйВиЭн-ийн санхүүжүүлэгч ОТ төсөлд зориулан гуравдагч талын Төслийн санхүүжилтийн хэлбэрээр авсан хөрөнгийн бүрэн хэмжээний өртөг зардал дээр татварын шаардлагыг харгалзан хураамж ногдуулах, эсхүл аливаа ашиг буюу нэмэлтийг дамжуулахгүй байхыг Хувь нийлүүлэгчид хүлээн зөвшөөрч байна.”

Санамж бичгийн төсөл –

Санхүүжилт

3.7

А.Төслийн санхүүжилт (ХНГ-нд тодорхойлсон), банкны бусад санхүүжилт, бүтээгдэхүүн урьдчилан борлуулах офтэйк гэрээ болон санхүүжилтийн бусад хэлбэрээр 6 хүртэлх тэрбум ам.долларыг босгоно;

Б.ОТ ХХК нь бэлэн мөнгийг оновчтой удирдах замаар (“төвлөрүүлэлт”) ОТ ХХК-ийн санхүүжилтийн зардлыг хамгийн хямд байлгахыг зорих болно. Үүнд:

Санамж бичгийн төсөл – Санхүүжилт

3.7

I. Төслийн Санхүүжилтийн эх үүсвэр болон үйл ажиллагаанаас олох бэлэн мөнгөний бүх илүүдэл дүнг илүү өндөр зардалтай Хувьцаа эзэмшигчийн одоогийн зээл ба Хувьцаа эзэмшигчийн өрийг (НӨОДТХНГ-нд тодорхойлсончлон) түр бууруулахад ашиглана;

II. Рио Тинтогийн Гүйцэтгэлийн Баталгааны Шимтгэлийг тооцохгүй нөхцөлтэйгээр илүүдэл эх үүсвэр дүнг 2-р шатны бүтээн байгуулалтад шаардагдах хүртэл нь Рио Тинто группын тайлан тэнцэлд шилжүүлнэ. Рио Тинтогийн тайлан тэнцэлд тусгагдсан бүх мөнгөн дүн нь 4.2 тэрбум ам.доллар эсхүл Төслийн санхүүжилтийн нийт дүнгээс хэтрэхгүй байна.

III. хөрөнгийг (санхүүжилтийн болон зээлийн баталгаажуулалтын шимтгэл, холбогдох татвараас үлдэж буй цэвэр дүн) 2 дугаар үе шатны барилгын ажилд шаардагдах тохиолдолд ОТ ХХК-ийн хүсэлтээр ОТ-д буцаан шилжүүлнэ;


Дүгнэлт:

1. Нийт 6 тэрбум ам.долларын санхүүжилтийг бүрдүүлэх,
2. Үүнээс 4.2 тэрбум ам.долларыг төслийн санхүүжилтээр босгон Рио Тинто өөрийн тайлан тэнцэлд шилжүүлэх,


ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТ, ТҮҮНИЙ САНХҮҮГИЙН ҮР ДАГАВАР

Энэхүү төслийн санхүүжилтээр ОТ бүлэг ордын далд уурхайн Хойд Хюго ордын давхарга 1-ийн бүтээн байгуулалтын ажлыг хийхээр тооцсон байна

ТС-ийн үндсэн үзүүлэлт: 2012 он



ТС-ийн үндсэн үзүүлэлт: 2014 он



АСУУДАЛ 8: : РИО ТИНТО-ИЙН НЭМЭЛТ, АШИГ ХУРААМЖ

Хувь нийлүүлэгчдийн гэрээ

8

ХНГ 14.в - “Компанид зориулан аливаа Хувь нийлүүлэгч болон/эсхүл АйВиЭн-ийн санхүүжүүлэгч ОТ төсөлд зориулан гуравдагч талын Төслийн санхүүжилтийн хэлбэрээр авсан хөрөнгийн бүрэн хэмжээний өртөг зардал дээр татварын шаардлагыг харгалзан хураамж ногдуулах, эсхүл аливаа ашиг буюу нэмэлтийг дамжуулахгүй байхыг Хувь нийлүүлэгчид хүлээн зөвшөөрч байна.”

Санамж бичгийн төсөл – Санхүүжилт

3.7.6

iv. Тус санхүүжилтийн эх үүсвэрийг ТЭЗҮ-ийн хөрөнгө оруулалтын хуваарьт үндэслэн 2 дугаар үе шатны барилгын ажлыг ирэх 5 жилийн дотор санхүүжүүлэхэд зарцуулна;

v. батлагдсан мөнгөн хөрөнгийн шаардлагыг ОТ ХХК-иас хүлээж авсанаас 21 хоногийн дотор Рио Тинто санхүүжилтийн хөрөнгийг буцаах болно;

vi. санхүүжилтийн эх үүсвэрийг буцаан татах нөхцөл нь Хувь нийлүүлэгчдийн одоогийн зээлтэй ижил нөхцөлтэй буюу, одоо мөрдөгдөж буй LIBOR+6.5% хүүгийн хувь хэмжээг хадгална;

ДУГНЭЛТ:

1. Хувь нийлүүлэгчдийн гэрээний заалт болон гэрээгээр тохирсон үндсэн зарчмаа зөрчин “Баталгааны шимтгэл” гэх хураамжийг ОТ ХХК-д ногдуулах,
2. Баталгааны шимтгэлийн зөвхөн зээлийн үндсэн дүнд ногдох хэмжээ нь 536 сая ам.доллар бөгөөд энэ хэмжээ цаашид өснө (Баталгаа гаргасан 4.2 тэрбум ам.долларын үндсэн зээлээс гадна хүү болон бусад хураамжаас нэмж шимтгэл авна).

Санамж бичгийн төсөл –

Санхүүжилт

- 3.7.6 vii. ОТ ХХК-иас тухай бүрт төлөгдөх Рио Тинтогийн Гүйцэтгэлийн Баталгааны Шимтгэл нь, Төслийн Санхүүжилтийн төлөгдөөгүй үлдсэн үндсэн дүн, хүү, шимтгэл, төлбөрийн 1.9%-иас хэтрэхгүй байхыг Хөрөнгө оруулагчид зөвшөөрч байна.

viii. Рио Тинто-д шилжсэн эх үүсвэр нь баталгаа гаргасан хэмжээнээс бага байх тохиолдолд Рио Тинтогийн Гүйцэтгэлийн Баталгааны Шимтгэлийг тооцно. Үүний дүнд, баталгааны шимтгэлийн бодит үйлчлэх хүү 1%-иас бага байхаар тооцож байна.

АСУУДАЛ 9: ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН БАРЬЦАА БАТАЛГАА

Хувь нийлүүлэгчдийн гэрээ

9. ХНГ 14.г- Хувь нийлүүлэгч бүр энэхүү Гэрээний 14(а)-д заасан санхүүжилтийг олж авахын тулд нөгөө талдаа болон Компанид зохих бүх дэмжлэгийг үзүүлэх бөгөөд санхүүжилтийн аливаа зохицуулалт нь Монгол Улсын Засгийн газрын, эсхүл ТӨК-ийн өмч хөрөнгөд нөлөөлөхгүй.

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль

9. **4.8 дугаар зүйл.** 4.1.8.“улсын өр” гэж Засгийн газрын дотоод, гадаад зээл, санхүүгийн түрээс, Засгийн газрын гаргасан баталгаа, өрийн бичиг, төрийн болон орон нутгийн өмчит болон тэдгээр өмч давамгайлсан хуулийн этгээдийн ирээдүйд эргэн төлөх үүрэг хүлээсэн санхүүгийн бүх төрлийн төлбөрийн үүргийн мөнгөн дүн, түүнд ногдох хугацаа хэтэрсэн хүү, алданги, торгуулийн нийлбэрийг;

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

9. **8 дугаар зүйл.** Төрийн өмчийн талаархи Улсын Их Хурлын бүрэн эрх
1. Улсын Их Хурал төрийн өмчийн талаар дараах бүрэн эрхтэй:
4/ төрийн өмчийг барьцаалах, орон нутгийн өмчид шилжүүлэх тухай шийдвэр гаргах;

Санамж бичгийн төсөл – Санхүүжилт

- 3.8 МУЗГ нь зээлдүүлэгчдээс тавих нөхцөл, Төслийн санхүүжилтийн шаардлагуудыг дэмжиж, биелүүлж ажиллана. Үүнд Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн Төслийн санхүүжилтийн бичиг баримтуудын шаардлагын дагуух баталгааг хангах бүхий л арга хэмжээг авна. Мөн, ОТ-н ашиглалтын тусгай зөвшөөрөл, ХӨРОГ болон ХНГ-ний үр өгөөж ба ОТ ХХК-ийн үл хөдлөх хөрөнгүүдийг зээлдүүлэгчид барьцаална.

ДУГНЭЛТ:

1. ОТ ХХК-ийн нийт хөрөнгийн 34%-ийг МУЗГ эзэмшдэг бөгөөд Засгийн газрын хөрөнгийг барьцаалахад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг баримтлан холбогдох зөвшөөрлийг ЗГ, УИХ-аас авах ёстой. Энэ процессоос зайлсхийн хууль зөрчих болохоо баталгаажуулах.

ТӨСЛИЙН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТЭД ОРОЛЦОХООР СОНИРХОЖ БУЙ БАНК САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУД

Байгууллага	Хугацаа
ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУД:	
Олон Улсын Санхүүгийн Корпораци (IFC)	15 жил
Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (EBRD)	15 жил
Канадын Экспорт Хөгжлийн Агентлаг (EDC)	14 жил
АНУ-ын EXIM банк	14 жил
Австралийн Экспортын Санхүүжилт болон Даатгалын Корпораци (EFIC)	14 жил
АРИЛЖААНЫ БАНКУУД:	
MIGA □ даатгалтай	12 жил
“В” Зээл	12 жил
Даатгалгүй	12 жил
НИЙТ	\$4 тэрбум ойролцоогоор

АСУУДАЛ 10: : МЕНЕЖМЕНТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭМЭЛТ ТӨЛБӨР

Хөрөнгө оруулалтын гэрээ

9 ХӨРӨГ 16.29 “менежментийн үйлчилгээний төлбөр” гэж Хувь нийлүүлэгчдийн гэрээний 6.3-д заасны дагуу хийх ажил үйлчилгээний төлбөрийг;

ХНГ 7.2.в – “Гүйцэтгэх удирдлага Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад Менежментийн багаас үзүүлэх үйлчилгээ, тусалцаа нь инженеринг, үйл ажиллагаа, төлөвлөлт болон үнэлгээ, байгаль орчин, маркетинг, ханган нийлүүлэлт, хууль зүй, худалдаа, төлбөр тооцоо, санхүүгийн үйлчилгээ, түүнчлэн Үндсэн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад шаардлагатай гэж үзсэн бусад бүхий л үйлчилгээнээс бүрдэж болно.”

ДҮГНЭЛТ:

1. Хувь нийлүүлэгчдийн гэрээний дагуу Менежментийн багийн гүйцэтгэх ажил үүргийг Менежментийн баг болон Менежерийн гүйцэтгэх ажил үүрэг болгон 2 хувааж, нэмэлт төлбөр төлөхийг баталгаажуулах,
2. Рио Тинто группын зүгээс өмнө нь буюу одоо хүртэл энэхүү нэмэлт төлбөрийг авч байснаа хүлээн зөвшөөрч түүнийгээ манай талаар баталгаажуулах,

Санамж бичгийн төсөл –

Бусад асуудлууд

4.1

“ОТ ХХК нь Рио Тинтогийн ОТ-н “Менежер”-ийн үүрэг хариуцлагыг Менежментийн Үйлчилгээний гэрээгээр албажуулах, тодруулбал Хувь нийлүүлэгчдийн гэрээний дагуу, Рио Тинто-ийн нэгжийг Менежментийн багаар томилох Менежментийн Үйлчилгээний Гэрээг байгуулна.”

ОТ ХХК нь Рио Тинто-той хамааралтай этгээдтэй Үйлчилгээний гэрээ байгуулах бөгөөд үүгээр Рио Тинто группын ОТ ХХК-д хийх үйлчилгээг гүйцэтгэх буюу үйлчилгээ тус бүрт төлбөр тооцож авна. Энэхүү үйлчилгээг Рио Тинто группын зүгээс гүйцэтгэх хангалттай дадлага туршлага, боловсон хүчинтэй бөгөөд ОТ ХХК-ийн хүсэлтийн хүрээнд хийнэ. Энэхүү үйлчилгээний гэрээ нь Рио Тинто группын зүгээс ОТ ХХК-д өнгөрсөн хугацаанд үзүүлсэн үйлчилгээний одоогийн гэрээний зохицуулалтыг орлуулах бөгөөд Рио Тинто групп төлбөрийг тэдгээр үйлчилгээнийхээ хүрээнд авч байсан болно.

ОТ ХХК нь ЭОТ-той Үйлчилгээний гэрээ байгуулах бөгөөд үүгээр ЭОТ-ийн ОТ ХХК-д хийх үйлчилгээг гүйцэтгэх буюу үйлчилгээ тус бүрт төлбөр тооцож авна. Энэхүү үйлчилгээг ЭОТ-ийн зүгээс гүйцэтгэх хангалттай дадлага туршлага, боловсон хүчинтэй бөгөөд ОТ ХХК-ийн хүсэлтийн хүрээнд хийнэ.

2009 оны Хувь Нийлүүлэгчдийн гэрээгээр

Рио Тинто-гоос 2014 онд ирүүлсэн Санамж бичиг, бусад Менежментийн үйлчилгээний гэрээнүүдээр

МЕНЕЖМЕНТИЙН БАГ

РИО ТИНТО, эсхүл РИО
ТИНТОГИЙН ЭТГЭЭД (ХНГ 7.4)

ЧИГ ҮҮРЭГ (Үйлчилгээ, тусалцаа):

инженеринг,
үйл ажиллагаа,
төлөвлөлт болон үнэлгээ,
байгаль орчин,
маркетинг,
ханган нийлүүлэлт,
хууль зүй,
худалдаа,
төлбөр тооцоо,
санхүүгийн үйлчилгээ,
түүнчлэн Үндсэн үйл ажиллагааг үр дүнтэй
зохион байгуулахад шаардлагатай гэж үзсэн
бусад бүхий л үйлчилгээ.

Менежментийн үйлчилгээний төлбөр

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хүртэл 3%
Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас хойш 6%
(Үндсэн хөрөнгө болон үйл ажиллагааны нийт зардлаас)

МЕНЕЖМЕР

РИО ТИНТО

Менежментийн Үйлчилгээ:

Рио Тинто-гийн дээд
удирдлагаас үзүүлэх
стратегийн зөвлөгөө, дэмжлэг,

Компанид үзүүлэх аливаа
санхүүжилтийг зохион
байгуулах (төслийн сан.орсон),

Рио Тинто группын ерөнхий
дэмжлэгийн үр өгөөж

Менежментийн үйлчилгээний төлбөр

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа
хүртэл 3%
Үйлдвэрлэлийн үйл
ажиллагаанаас хойш 6%
(Үндсэн хөрөнгө, үйл
ажиллагааны нийт зардлаас)

МЕНЕЖМЕНТИЙН БАГ

РИО ТИНТОГИЙН
ЭТГЭЭД

Тусалцааны үйлчилгээ:


инженеринг,
үйл ажиллагаа,
төлөвлөлт болон үнэлгээ,
байгаль орчин,
маркетинг,
ханган нийлүүлэлт,
хууль зүй,
худалдаа,
төлбөр тооцоо,
санхүүгийн үйлчилгээ,
түүнчлэн Үндсэн үйл
ажиллагааг үр дүнтэй зохион
байгуулахад шаардлагатай гэж
үзсэн бусад бүхий л үйлчилгээ.

Маркетингийн Үйлчилгээ.

Төлөгдөх Зардал
Сар бүр нэхэмжлэхээр
төлөгдөх (хяналтгүй)

МЕНЕЖМЕНТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙГ «+» САНАЛ

ХөрОГ, ХНГэрээгээр тохирсон дээр нэмж их хэмжээний төлбөр авах санал тавьж байна



САНАМЖ БИЧГИЙН ТӨСЛИЙН ҮР ДАГАВАР

ЭРХЗҮЙН ҮР ДАГАВАР

ХӨРӨГ, ХНГ болон
ТЭЗҮ-ийн үндсэн зарчмыг өөрчлөх

МУ-д хүчин төгөлдөр хуулиар
тогтоосон хэм хэмжээ мөрдөгдөхгүй болох

ХӨРӨГ-ээр хүлээсэн
санхүүжилтийн үүрэг хариуцлага, эрсдэлээ
Рио Тинто нь ОТ болон банкуудад шилжүүлэх

Санамж бичгээр ХӨРӨГ, ХНГ-нээс
давж үйлчлэх эрхзүйн баримт бичиг бий болгох,
түүний зохицуулалт үйлчлэх

ХӨРӨГ ХНГ-нд цаашид өөрчлөлт оруулах
боломжгүй болох, эрхзүйн аливаа маргаан үүсгэх
боломжгүй болох

САНХҮҮГИЙН ҮР ДАГАВАР

Анхны хөрөнгө оруулалтын зардлын хэтрэлтийг хүлээн
зөвшөөрүүлэх

Хуулийн хүрээнд Монгол Улсад төлөх татвар, төлбөрийн
хэмжээг бууруулах

Төслийн санхүүжилтээс гүйцэтгэлийн баталгааны шимтгэл
нэрээр Рио Тинто нэмэлт төлбөр авах

Менежментийн үйлчилгээний төлбөрөөс гадна
нэмэлт төлбөрийг Рио Тинто хяналтгүйгээр авах

Ирээдүйд ногдол ашгаар авах байсан үр өгөөжөө зээлийн
эргэн төлөлт байдлаар богино хугацаанд эргүүлэн авах

ОТ ХХК-ийн хөрөнгө, тусгай зөвшөөрлийг барьцаалан
зээлсэн 4.2 тэрбум ам.долларын Төслийн санхүүжилтийн
эх үүсвэрийг Рио Тинто нь тодорхойгүй хугацаагаар өөрөө
авч ашиглах

НЭМЭЛТ БАРИМТ 1: “ТАТВАРЫН АРГАЧЛАЛ” БАЙГУУЛАХ АЛБАН ТООТ (2014.10.01)



Y. Batmagnai, Commissioner
General Department of Taxation, Mongolia

1 October 2014

Dear Mr. Batmagnai,

Re: Resolution No 77 of Tax Dispute Resolution Council

We would like to follow up with you concerning discussions between OT LLC's shareholders regarding OT LLC's tax issues. OT LLC and its two international investors, Rio Tinto and Turquoise Hill, have spent considerable time and effort reviewing the ruling of the Tax Dispute Resolution Council (Resolution 77) issued on September 10, 2014. While we welcome the reduction in the amount of the imposed fines and penalties, we do not fully understand the basis for the decisions and seek clarity from the Mongolian Tax Authority on the findings in the ruling.

The shareholders of OT LLC, together with additional Government representatives, agreed that OT LLC needs to agree with the Mongolian Tax Authority the contents of a "Tax Manual" to clarify and confirm the interpretation and practical application of, and requirements for compliance with, various tax regulations applicable to OT LLC in accordance with the Investment Agreement. This includes: a) resolution of the remaining issues arising from the "Tax Manual"; b) calculation and the amount of OT LLC's Investment Tax Credit; c) the calculation of royalties; d) offshore services withholding tax; e) other matters including depreciation. In light of the above, Oyu Tolgoi and the investors have agreed to commence international arbitration at the end of the notice period, but until these matters are clarified and fully resolved we are not able to withdraw the dispute notice and we fully reserve all of our rights under Mongolian and international law.

Currently OT is preparing a form of Tax Manual which incorporates the lessons learnt from the Phase 1 developments. We intend to send you a draft Tax Manual by the end of next week for your review. Our intention is to work jointly with Tax Authority representatives on the draft Tax Manual. We confirm that representatives of OT LLC and its investors have been appointed and will make themselves available to meet Tax Authority representatives to discuss and accelerate resolution of this matter. We agree that we will be able to reach common understanding in coming weeks, and both OT LLC and MA will be in position to sign an agreed Tax Manual by the end of this month, after the approval of the Board of OT LLC.

Yours sincerely,
Alexandre Jacques
Chief Executive Officer
Rio Tinto

Karen Kennedy
Chief Executive Officer
Turquoise Hill Resources

Craig Kennel
President and CEO
Oyu Tolgoi LLC

Copy to: Da Ganbold, CEO, Erdemes Oyu Tolgoi LLC

ХӨРӨГ-ний 3 ТАЛ

+

Монголын талаас албан тоотоор хариу өгсөн тохиолдолд эрхзүйн талаасаа ХӨРӨГ-ний бүх талууд оролцон гэрээнд тухайн асуудлаар нэмэлт, өөрчлөлт оруулсан гэж үзэхээр байна. Үүнд:

- A. Татварын акттай холбоотой үлдсэн асуудал,
- B. Хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлтийг тооцох аргачлал,
- C. Ашиг малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох аргачлал,
- D. Гадаадад хийгдсэн үйлчилгээний суутган татвар,
- E. Элэгдэл тооцох болон бусад.

Жич: Хэдий хувийг ЭОТ-д хаягласан ч албан ёсоор ирүүлээгүй.



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. Татварын аргачлалыг батлах,
2. Санамж бичиг болон түүний аль нэг асуудлаар шийдвэр гаргах,
3. Менежментийн үйлчилгээний нэмэлт гэрээ, нэмэлт төлбөр:
 - А.Рио Тинтог Менежментийн үйлчилгээний гэрээгээр менежерээр томилох,
 - Б.Рио Тинтогийн этгээдийг Туслах үйлчилгээний гэрээгээр Менежментийн багаар томилох.

Хууль тогтоомж, ХӨРӨГ, ХНГ зөрчсөн, Рио Тинтод үлэмж хэмжээний үр өгөөж нэмэх асуудлууд

ДҮГНЭЛТ:

1. ХНГ-ний хүрээнд Монголын талын ТУЗ-ийн гишүүд хориг тавих эрхгүй(ХНГ 5.6.д).
2. ТУЗ-ийн хурлын түвшинд олонхоороо хүчээр шийдэх, хамааралгүй бусад асуудлаар болзолт нөхцөл тулган шийдэх хандлагатай байна. 3. Энэ тохиолдолд ХӨРӨГ-ний дагуу арбитр-т хандах шаардлагатай болно(ХӨРӨГ 10.7).

2010 БОЛОН 2014 ОНЫ ТЭЗҮ-ИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Энэхүү төслийн санхүүжилтээр ОТ бүлэг ордын далд уурхайн Хойд Хюго №1 амны бүтээн байгуулалтын ажлыг хийхээр тооцсон байна

Оюу Толгой төслийн 2010 болон 2014 оны ТЭЗҮ-ийн үндсэн үзүүлэлтийн харьцуулалт

№	Үзүүлэлт	Хэмжих Нэгж	2010 оны ТЭЗҮ	2014 оны шинэчлэгдсэн ТЭЗҮ	Зөрүү (± %)
1	Үйлдвэрлэл явагдах хугацаа	жил	65	94	+3.0%
2	Зэсийн үнэ	\$/фунт	1.96	3.08	+39.3%
3	Алтын үнэ	\$/унц	875.0	1,160.3iii	+43.0%
4	Олборлох Нийт хүдэр	сая тонн	2,801	3,525	+19.1%
5	Баяжмал дахь металл зэс	мян.тонн	22,768	25,614v	+6.3%
6	Баяжмал дахь металл алт	мян.унц	25,874vi	27,888v	+0.4%
7	Засгийн газрын хүртэх өгөөж	сая \$	36,327	38,875	+7.0%
8	Хөрөнгө оруулагчийн өгөөж	сая \$	31,887	28,352viii	-11.1%
9	Анхны хөрөнгө оруулалтын зардал	сая \$	5,174	13,241	+155.9%
10	Хөрөнгө оруулалтын Нийт зардал	сая \$	14,648	27,150	+85.3%
11	Үйл ажиллагааны Нийт зардал	сая \$	20,355VI	48,441xiii	+137.9%

2010 оны ТЭЗҮ-ийн 1.2.3 дахь хэсэг болон 11.2 дахь хэсэгт тус тус дурдсан.
 2014 оны ТЭЗҮ-ийн төслийн Executive Summary 1-34 дүгээр хуудсанд дурдсан.
 2014 оны ТЭЗҮ-ийн төслийн Executive Summary 1-36 дугаар хуудсанд дурдсан
 2010 оны ТЭЗҮ-ийн 1.2.3 дахь хэсэгт нийт олборлох хүдрийн хэмжээг заасан бөгөөд энэ нь ил уурхай, далд уурхай (Хойд Хюго 1 болон 2-р давхар; Өмнөд Хюго; Херуга-с олборлохоор тооцсон)-н олборлох нийт хүдрийн хэмжээ юм.
 2014 оны ТЭЗҮ-ийн төслийн Executive Summary 1-35 дугаар хуудсанд дурдсан
 2010 оны ТЭЗҮ-ийн 1.2.5 дахь хэсгийн 1.8 дахь хүснэгтэд байгаа.
 2010 оны ТЭЗҮ-ийн 18.1.4 дэх хэсгийн 18.4 дэх хүснэгтэд байгаа.
 2013 оны ТЭЗҮ-ийн төслийн 4-23 дугаар хуудас дахь 12-4-18 хүснэгтэд дурдсан.
 2010 оны ТЭЗҮ-ийн 18.1.4 дэх хэсгийн 18.5 дахь хүснэгтэд байгаа.
 2010 оны ТЭЗҮ-ийн 14.3.1 дэх хэсгийн 14.2 дахь хүснэгтэд байгаа.
 Танилцуулга №6-ийн 6 дугаар хуудсанд тайлбарласан байгаа
 2010 оны ТЭЗҮ-ийн 18.13 дахь хүснэгтэд байгаа.
 2013 оны ТЭЗҮ-ийн төслийн 4-20 дугаар хуудас дахь 12.4-17 дугаартай хүснэгтэд байгаа. Мөн ТЭЗҮ-ийн төслийн 12.2 дахь хэсгийн 12.2-4 дэх хүснэгтэд нийт хөрөнгө оруулалтын зардлыг 22,516 сая ам.доллар гэж тусгасан байгаа.

Хөрөнгө оруулагчийн гэрээгээр хүлээсэн үүрэг

1. Төслийн бүх санхүүжилтийг хариуцах,
2. Техник технологи, ур чадвартай байх, (заавал мөрдөх тооцоолол бүхий ТЭЗҮ)

Эдгээр үндсэн үүргийг хангаснаар хөрөнгө оруулагчийн эрх олгосон.

РИО ТИНТО-ГИЙН ЗҮГЭЭС ҮҮСГЭЭД БАЙГАА БОЛОН БОЛЗОШГҮЙ* ХӨРӨГ-НИЙ ЗӨРЧЛҮҮД:

1. Санхүүжилтийг бүрдүүлэх
2. *МУЗГ 34%, эзэмшил эрсдэлд орох
3. ТЭЗҮ-ийн дагуу төслийг хэрэгжүүлэх
4. Төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх тухай ЗГ-т мэдэгдэх
5. Далд уурхайн барилга бүтээн байгуулалтын ажлыг зогсоох

Rio Tinto

ЯАРАЛТАЙ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ



МОНГОЛЫН ТАЛ ЦААШИД БАЙНГА САНАЖ БАРИМТЛАХ ЗАРЧИМ:

1. Хөрөнгө оруулалтын гэрээ МУ-ын хууль тогтоомжид нийцсэн.
(цаашдын аливаа гэрээ хэлцэл хуулинд нийцсэн байх)

2. Батлагдсан ТЭЗҮ-д үндэслэж санхүүгийн тооцоолол хийгдсэн.
(Хөрөнгө оруулагчийн парадокс)

3. Хөрөнгө оруулагчийн санхүүгийн үүрэг,
Монгол Улсын хүчин төгөлдөр 8 татварын тогтворжуулалтын
үндсэн дээр талуудын үр өгөөжийг (53/47) баталгаажуулсан.
(Гэрээгээр хүлээсэн санхүүгийн үүргийг чөлөөлж, хөнгөлж
болохгүй. Үр өгөөжийн харьцаанд шууд нөлөөлнө.)

